



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

“Хүүхэд, залуучуудын хөгжил,  
хамгаалал-2028” арга хэмжээ батлах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн хүүхэд, залуучууд, гэр бүлийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, хүүхэд, залуучуудын эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, гэр бүлийн боловсрол олгох, үе тэнгийн дээрэлхэлтийг арилгах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж, хүүхэд залуучуудад ээлтэй орчин бүрдүүлэх зорилго бүхий “Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Дарга

Т.УЛАМБАЯР



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2025 оны .... дугаар сарын .....-ны  
өдрийн ..... дугаар тогтоолын хавсралт

## “ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ-2028 “ АРГА ХЭМЖЭЭ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн хэмжээнд хүүхэд, залуучуудад чиглэсэн нэгдсэн бодлогыг тодорхойлж, дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын дагуу Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, “Алсын хараа-2025” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан “Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал-2028” арга хэмжээг боловсрууллаа.

Чингэлтэй дүүргийн хэмжээнд өнгөрсөн 4 жилийн хугацаанд “Жаргалтай гэр бүл” хөтөлбөр, “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”, “Хөгжлийн үндэс” төсөл, “Гэр бүл 2024” арга хэмжээ зэрэг гэр бүлийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн дүүргийн хэмжээнд нийт 1340 өрхийг хамруулж, хүүхдийн эрх, хамгааллын асуудлаарх хууль, эрх зүйн орчныг сайжруулах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжихэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлсэн нь тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага мэдээлэл буурахгүй хэвээр байна.

Дүүргийн хэмжээнд нийт хүн амын 35,3 хувь буюу 0-18 насны 50,920 хүүхэд байна. Хүүхдийн тусlamжийн 108 утсанд 2021-2024 онд нийт 2290 хүүхдийн дуудлага бүртгэгдэж, сүүлийн 2 жилийн хугацаанд 10,2%-аар нэмэгдсэн ба дүүргийн Гэрч хохирогчийг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төвд 2020-2024 оны хугацаанд нийт 1056 хүүхдийг хүлээн авч, 2021-2024 оны байдлаар 537 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөөг хүргэж ажилласан байна. Мөн дүүргийн хэмжээнд асрамж халамж, харгалzan дэмжигч үрчлэлтийг 2021-2024 оны байдлаар 296 хүүхдэд захирамжаар шийдвэрлэж, асрамж халамжийн байгууллагад шилжүүлэн асрамжуулж байна.

Хүүхдийн эрх зөрчигдэж, хүүхэд хүчирхийлэлд өртөж буй голлох шалтгаан нь гэр бүл салалт, эцэг эхийн мэдлэг боловсролын түвшин, өрхийн орлого, амьжиргааны түвшин, үр хүүхдээ хүмүүжүүлэх арга барил дутмаг, хорт зуршилд хэт их автсан байдал зэргээс шалтгаалан хүүхдийн хөгжих, хамгаалагдах эрх зөрчигдэж байгаа юм. Иймд гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, эцэг эх, насанд хүрэгчдийн

үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллыг дэмжих хэрэгцээ шаардлага бий болж байна.

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, тэдний эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч хөгжих, хамгаалуулах эрхийг хангах, гэр бүлийн боловсрол олгох, үе тэнгийнхний дээрэлхэлтийг арилгах, хүүхдийн эсрэг хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хүүхэд залуучуудад ээлтэй орчныг бүрдүүлэх зорилго бүхий "Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал-2028" арга хэмжээг хэрэгжүүлэхээр дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан.

Иймд хүүхдийн залуучуудын хөгжил, хамгааллын үйлчилгээг дэмжих, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах асуудлыг эсэргүүцэх, илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, хүүхдийн аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэх, сурч боловсрох, хөгжих хамгаалуулах, сэтгэл зүйн хэвийн байдлыг бий болгох, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах чиглэлээр нийгмийн тусlamж үйлчилгээг бодитой үзүүлэх талаарх үйл ажиллагааг салбарын байгууллагуудын оролцоотой хамтран хэрэгжүүлэхээр дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг тус тус үндэслэн хүүхэд, залуучуудын хөгжил хамгаалалд чиглэсэн арга хэмжээг боловсруулах хэрэгцээ шаардлагатай байгаа юм.

### **Хоёр.Арга хэмжээний зорилго**

Чингэлтэй дүүргийн хүүхэд, залуучууд, гэр бүлийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, хүүхэд, залуучуудын эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, гэр бүлийн боловсрол олгох, үе тэнгийн дээрэлхэлтийг арилгах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж, хүүхэд залуучуудад ээлтэй орчин бүрдүүлэхэд арга хэмжээний зорилго оршино.

### **Гурав.Арга хэмжээний зорилт**

**Зорилт 1.Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлээр хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлнэ.**

**Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

1.1.Хүүхдийн эрхийн зөрчил, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, эрсдэлт нөхцөлд амьдарч буй зорилтот бүлгийн хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэн, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, шаардлагатай тохиолдолд Түр хамгаалах байранд байрлуулна.

1.2.Гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч, холбогдогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг туслалцаанд холbon зуучилна.

1.3.Хүүхдийн тоглоомын талбайн өрөнхий шаардлага MNS 6751-2019 стандартын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг холбогдох газруудтай хамтран улирал бүр зохион байгуулж, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

1.4.“Хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарын утасны үйлчилгээний төв”-өөс шилжсэн дуудлагын дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлнэ.

1.5.Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон зорилтот бүлгийн иргэдийг “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-өөр дамжуулан сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулж, шаардлагатай үйлчилгээнд холbon зуучилна.

1.6.Хүүхэд, өсвөр үеийнхнийг аливаа осол гэмтэл, хорт зуршил, гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, сургалт, нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулна.

#### **Хүрэх үр дүн:**

-Зорилтот болон гэр бүлийн хохирогч, гэмт хэргийн гэрч, хохирогч, холбогдогч хүүхдүүдийг илрүүлж, хүүхэд хамгааллын болон нийгэм сэтгэл зүй, бусад шаардлагатай үйлчилгээг түргэн шуурхай, үр дүнтэй хүргэнсээр тэдний хэвийн амьдралдаа эргэн орох, улмаар хэвийн өсөж, хөгжих эрх хангагдаж, нөхцөл бүрдсэн байна.

-Хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдэж, тэдний эрүүл, аюулгүй амьдрах, өсөж хөгжих эрх хангагдсан байна.

-Хүүхэд, өсвөр үеийнхэн, эцэг эх, насанд хүрэгчдэд хүүхдийг аливаа осол, хорт зуршил, гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг, мэдээллийг үе шаттай хүргэнсээр хүүхдийн осол гэмтэлд өртөх, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлсэн байна.

**Зорилт 2.Хүүхэд, залуучуудын хөгжил оролцоог дэмжих, хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлнэ.**

#### **Зорилт 2-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

2.1.Хүүхдийн оролцооны байгууллагуудыг дэмжих, хамтран ажиллах, тэдгээрийн идэвхтэн хүүхдүүдээр дамжуулан өсвөр насын хүүхдүүдэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулна.

2.2.Хүүхдийн оролцоог хангасан Нөлөөллийн ажил, Хүүхдийн чуулган, Хүүхдээ сонсох аяныг жил бүр зохион байгуулж, шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог нэмэгдүүлнэ.

2.3.Хүүхдийн оюун ухаан, авьяас чадварыг нээн хөгжүүлэх хувь хүний хөгжил төлөвшлийг дэмжих чиглэлээр олон талт сургалт, нөлөөллийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулна.

2.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний эцэг эх, гэр бүлийн гишүүдийн хөгжил оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.5.Гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллага, төр, төрийн бус байгууллага, дэмжих бүлэг, сайн дурын байгууллагуудтай хамтран сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.

2.6.Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг үе шаттай зохион байгуулна.

2.7.Гэр бүлийн гишүүдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжил олгох, сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.8.Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх салбар дундын уялдаа холбоог сайжруулна.

2.9.Хамтарсан багийн үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих, урамшуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

#### **Хүрэх үр дүн:**

-Хүүхдийн талаарх шийдвэр гаргалтад тэдний санал бодол тусгагдсан байна.

-Хүүхдийг сургах, хөгжүүлэх, нийгэмшүүлэх талаар олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хүүхдийн сурч хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрх хангагдана.

-Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн гишүүдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжил олгох сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэнээр хүүхдийн ядуурал багасаж, зорилтот бүлгийн хүүхдийн тоо буурна.

-Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг чадвар дээшилж, байгууллага хоорондын уялдаа холбоо сайжирч, улмаар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл буурна.

-Хамтарсан багийн кейс менежмент сайжирч, хүүхэд хамгааллын тогтолцоо бэхэжнэ.

#### **Зорилт 3.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжинэ.**

#### **Зорилт 3-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

3.1.Залуучуудын оролцооны байгууллагуудыг дэмжиж хамтран ажиллах, залуучуудад чиглэсэн олон талт арга хэмжээ, сургалт нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулна.

3.2. Залуучуудын эрүүл мэндийг дэмжих, нөхөн үргижүй, гэр бүлийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулна.

3.3. Оюутан, залуучуудын сурах, хөгжих, хөдөлмөрлөх, хувиараа бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4. Залуучуудын мэдлэг боловсрол, хувь хүний төлөвшил, авьяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээ зохион байгуулна.

3.5. Ахлах, дунд ангийн сурагчдад мэргэжил сонголтын талаарх мэдээлэл сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

3.6. Залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих чиглэлээр үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

3.7. “Менторшип хөтөлбөр”-ийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллана.

3.8. Залуучуудыг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, “Мөрийтэй тоглоом” болон “Цахим гэмт хэрэг”-тэй тэмцэх нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

### **Хүрэх үр дүн:**

-Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжилд оролцох, сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцох оролцоог дэмжиж, эрүүл, аюулгүй амьдрах, хөгжих орчин бүрдсэн байна.

### **Дөрөв.Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчмууд**

Арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг баримтална.

-Арга хэмжээний зорилго, зорилтууд хууль, эрх зүйн акт, тогтоол, шийдвэрт нийцсэн байх

-Арга хэмжээний зорилго бодитой, зорилтууд хэрэгжихүйц байх

-Арга хэмжээний хэрэгжилт нь төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, иргэд, хүүхэд, залуучууд, олон нийтийн идэвх санаачилга, тэгш оролцоонд тулгуурласан байх;

### **Тав.Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт**

5.1. “Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал-2028” арга хэмжээг 2025-2028 он хүртэл нийт 4 жилийн хугацаанд 3 зорилт, 23 үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

5.2. Арга хэмжээний санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.2.1. Улс, нийслэлийн төсөв

5.2.2. Орон нутгийн төсөв

5.2.3. Олон улсын болон төрийн бус байгууллагын дэмжлэг

5.2.4. Бусад эх үүсвэр

### **Зургаа.Арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт**

6.1.Арга хэмжээний хэрэгжилтийг дүүргийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн хэмжээнд удирдлага, төлөвлөлт, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, иргэд, хүүхэд, залуучууд, олон нийтийн идэвх санаачилга, тэгш оролцоонд тулгуурлана.

6.3.Арга хэмжээний хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн цахим сүлжээгээр тогтмол сурталчлан ажиллах ба хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын чиглэлээр нэвтрүүлсэн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах чиглэлд анхаарч ажиллана.

### **Долоо.Арга хэмжээний хэрэгжилтийн хяналт шинжилгээ,**

**үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт**

**Хяналт-шинжилгээ, үнэлгээ:**

- Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь оролцогч талуудыг тэгш оролцоог хангаж, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ба үр дүнгийн хэрэгжилтийг жил бүр гаргаж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаанд тайлagnana.
- Арга хэмжээний хэрэгжилтийг зорилтын биелэлт, үйл ажиллагааны чиглэлийн үр дүнгээр үнэлнэ.

**Арга хэмжээний үр дүн:**

- Чингэлтэй дүүргийн хүүхэд, залуучууд, гэр бүлийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, хүүхэд, залуучуудын эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, гэр бүлийн боловсрол олгох, үе тэнгийн дээрэлхэлтийг арилгах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

**Шалгуур үзүүлэлт:**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин			
				2025 он	2026 он	2027 он	2028 он
1	2	3	4				5
Зорилт 1.Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлээр хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлнэ.							
1.1	Хүчирхийлэлд өртсэн хүүхдүүдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ хүрсэн байдал	Хувь	100	100	100	100	100
1.2	Гэмт хэргийн зөрчлийн гэрч хохирогч холбогдолгоч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн арга хэмжээний хэрэгжилт	Хувь	100	100	100	100	100
1.3	Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага MNS 6751-2019 стандартын хяналт хэрэгжилтэд шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгасан байдал	Хувь	80	100	100	100	100
1.4	Хүүхдийн тусlamжийн 108 тусгай дугаарын утасны үйлчилгээний төв"-өөс шилжсэн дуудлагын шийдвэрлэлт	Хувь	90	95	100	100	100
1.5	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөс зөвлөгөө авсан иргэдийн тоо	Toо	156	400	600	800	1000
1.6	Хүүхэд, ёсвэр үеийнхнийг аливаа хорт зуршил гэмт хэрэг, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, сургалт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах арга хэмжээний тоо	Toо	6	10	12	13	14
Зорилт 2.Хүүхэд, залуучуудын хөгжил оролцоог дэмжих, хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлнэ.							
2.1	Хүүхдийн оролцооны байгууллагуудыг дэмжих, хамтран ажилласан арга	Toо	4 1000	5 1250	6 2000	8 3000	10 4000

	хэмжээ болон хамрагдсан хүүхэд							
2.2	Хүүхдийн чуулган зохион байгуулж, хамруулсан хүүхэд	Too	-	1000	1500	2000	3000	
2.3	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажил, хамрагдсан хүүхэд	Too	-	4 1000	4 1500	5 2000	6 3000	
2.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний эцэг, эх гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зохион үйл байгуулсан ажиллагаа	Too	1	4	6	8	10	
2.5	Гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр Олон улсын байгууллага, тэр, тэрийн бус байгууллага, дэмжих бүлэг, сайн дурын байгууллагуудтай хамтран сургалт нөлөөллийн үйл ажиллагааны болон хамрагдсан иргэдийн тоо	Too	8 1200	10 2400	10 3000	10 4000	10 5000	
2.6	Гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдсан иргэдийн тоо	Too	1000	2000	3000	4000	6000	
2.7	Зорилтот өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байдал	Xувь	50	80	90	95	100	
2.8	Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт	Too	1	4	4	4	4	
2.9	Хамтарсан багийн үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих, урамшуулах чиглэлээр зохион үйл байгуулсан ажиллагаа	Too	2	2	2	2	2	
Зорилт 3. Залуучуудын хөгжил, оролцоог дэмжинэ.								
3.1	Залуучуудын чуулган, олон талт арга хэмжээ	Too	-	1000	1500	2000	3000	

	зохион байгуулж хамруулсан залуучууд						
3.2	Эрүүл мэнд, гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	Too		4	6	8	10
3.3	Тэтгэлэгт хамрагдсан залуучууд	Too	-	10	20	30	50
3.4	Зохион байгуулсан үйл ажиллагаа	Too	-	4	8	10	12
3.5	Ахлах дунд ангийн сурагчдад мэргэжил сонголтын талаар зохион байгуулсан сургалтын тоо	Too	-	2	4	6	8
3.6	Залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	Too	-	2	4	6	6
3.7	Менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал	Xувь	-	30	50	70	100
3.8	Залуучуудыг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх ажил, мөрийтэй тоглоом болон цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулсан нөлөөллийн үйл ажиллагааны тоо	Too	-	4	4	4	4